

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/249/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: [khurelbataart@audit.gov.mn](mailto:khurelbataart@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.15 № 4/32  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Онцгой байдлын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 45 арга хэмжээтэй баталснаас нийт 92.8%-тай дүгнэгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор байр ашиглалттай холбоотой зардлыг хэмнэж ажилласан байна.
- Төв аймгийн баруун, зүүн талын сумдаар өвөлжилт хүндэрсэн, малын халдварт өвчин гарсантай холбоотой аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шатахууны зардал шийдвэрлүүлэн арга хэмжээ авч ажилласан байна.
- Төсвийн шууд захирагч солигдсон байна.

### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

### 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

#### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	410,029,052.38	444,846,728.38
33	АВЛАГА	-	218,970.00
335	Бусад авлага	-	218,970.00
3351	Байгууллагаас авах авлага	-	218,970.00
35	БАРАА МАТЕРИАЛ	410,029,052.38	444,627,758.38
351	Түүхий эд материал	331,601,999.28	355,889,327.28
35110	Тусгай зориулалттай материал	331,537,499.28	355,824,827.28
35130	Эм боох материал	64,500.00	64,500.00
354	Хангамжийн материал	77,577,053.10	87,888,431.10
35410	Бичиг хэргийн материал	2,034,970.00	1,649,970.00
35420	Аж ахуйн материал	68,531,865.10	69,831,865.10
35430	Сэлбэг хэрэгсэл	3,696,000.00	8,656,000.00
35440	Түлш, шатах тослох материал	3,314,218.00	7,750,596.00
35600	Мал амьтад	850,000.00	850,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,066,261,116.94	5,456,823,469.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,066,261,116.94	5,456,823,469.07
392	Биет хөрөнгө	5,433,727,116.94	4,824,289,469.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,857,582,036.40	3,857,582,036.40
39202	Хуримтлагдсан элэгдэл	(527,277,677.43)	(629,578,486.03)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,124,179,971.00	2,763,174,398.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,399,020,674.36)	(1,492,321,603.05)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	568,843,793.54	625,853,793.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	(268,582,774.15)	(357,353,912.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,224,345.93	36,224,345.93
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,302,325.19)	(26,767,203.93)
39209	Зам, гүүрийн байгууламж	134,207,853.00	134,207,853.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(69,127,431.80)	(86,731,752.48)
393	Биет бус хөрөнгө	632,534,000.00	632,534,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	632,534,000.00	632,534,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,476,290,169.32	5,901,670,197.45
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,476,290,169.32	5,901,670,197.45
51	Засгийн газрын хувь оролцоо	6,476,290,169.32	5,901,670,197.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,307,549,861.72	1,307,549,861.72
51101	Өмч: - төрийн	1,307,549,861.72	1,307,549,861.72
512	Хуримтлагдсан үр дүн	4,388,857,404.47	3,814,237,432.60
51210	Өмнөх үеийн үр дүн	4,388,857,404.47	4,388,857,404.47
51220	Тайлант үеийн үр дүн	-	(574,619,971.87)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	779,882,903.13	779,882,903.13
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,476,290,169.32	5,901,670,197.45

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,335,140,494.00	2,634,741,852.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	593,777,919.00	347,011,652.82
120	Нийтлэг татварын бус орлого	593,777,919.00	347,011,652.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,470,000.00	41,425,585.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,470,000.00	41,425,585.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -ҮХ	296,027,800.00	47,600,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - БМ	271,280,119.00	257,986,067.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,741,721,575.00	2,287,730,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,712,317,400.00	2,251,149,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,712,317,400.00	2,251,149,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,404,175.00	36,580,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,068,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,706,000.00	27,125,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,629,675.00	9,455,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,582,170,700.99	3,110,085,292.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,582,170,700.99	3,110,085,292.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,533,899,808.99	3,078,749,137.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,253,920,227.00	1,807,926,483.00
210101	Үндсэн цалин	783,602,975.00	818,026,183.00
210102	Нэмэгдэл	430,658,752.00	950,003,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,658,500.00	39,897,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,037,109.00	52,601,426.00
210201	Тэтгэврийн даатгал	15,910,170.00	13,990,604.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,871,782.00	1,645,953.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,497,427.00	1,316,762.00
210204	Ажилгүйдлийн даатгал	314,075.00	277,278.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,443,655.00	35,370,829.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	238,396,346.00	276,037,443.91
210301	Гэрэл, цахилгаан	16,651,579.00	21,934,629.90
210302	Түлш, халаалт	209,870,620.00	241,653,365.01
210303	Цэвэр, бохир ус	11,874,147.00	12,449,449.00
2104	Хангамж, бараа материалын зардал	187,837,984.97	111,804,331.02
210401	Бичиг хэрэг	5,982,945.00	3,606,680.00
210402	Тээвэр, шатахуун	107,643,958.00	102,674,207.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,967,823.00	1,511,536.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	678,000.00	1,320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	71,565,258.97	2,691,907.92
2105	Нормативт зардал	173,417,414.00	185,767,849.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	886,800.00	328,920.00
210502	Хоол, хүнс	63,384,600.00	63,888,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	109,146,014.00	121,550,279.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,873,605.00	38,082,282.00
210604	Урсгал засвар	26,873,605.00	38,082,282.00
2107	Томилолт, зочны зардал	12,492,000.00	23,440,500.00
210702	Дотоод албан томилолт	12,492,000.00	23,440,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,500,578.00	15,917,706.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,200,000.00	9,455,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,328,000.00	1,612,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,720,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,809,374.00	1,835,374.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3,637,150.00	836,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,055,500.00	592,000.00
210807	Газрын төлбөр	1,749,954.00	1,586,532.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	580,424,545.02	567,171,115.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,085,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	575,339,545.02	567,171,115.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,270,892.00	31,336,154.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,534,000.00	8,483,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,534,000.00	8,483,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,736,892.00	22,853,154.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,736,892.00	22,853,154.99
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(247,030,206.99)	(475,343,439.73)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	99,276,532.14
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	99,276,532.14
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(99,276,532.14)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(247,030,206.99)	(574,619,971.87)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,741,721,575.00	2,287,730,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,741,721,575.00	2,287,730,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,712,317,400.00	2,251,149,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,712,317,400.00	2,251,149,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,404,175.00	36,580,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,068,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,706,000.00	27,125,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,629,675.00	9,455,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,741,721,575.00	2,287,730,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,741,721,575.00	2,287,730,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,693,450,683.00	2,256,394,045.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,253,920,227.00	1,807,926,483.00
210101	Үндсэн цалин	783,628,090.00	818,026,183.00
210102	Нэмэгдэл	430,633,637.00	950,003,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,658,500.00	39,897,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,037,109.00	52,820,396.00
210201	Тэтгэврийн даатгал	15,910,170.00	13,990,604.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,871,782.00	1,645,953.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,497,427.00	1,316,762.00
210204	Ажилгүйдлийн даатгал	314,075.00	277,278.00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,443,655.00	35,589,799.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	238,396,346.00	276,037,443.91
210301	Гэрэл, цахилгаан	16,651,579.00	21,934,629.90
210302	Түлш, халаалт	209,870,620.00	241,653,365.01
210303	Цэвэр, бохир ус	11,874,147.00	12,449,449.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,532,168.00	6,546,696.10
210401	Бичиг хэрэг	3,722,045.00	1,587,760.00
210402	Тээвэр, шатахуун	11,368,500.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,967,823.00	1,511,536.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	678,000.00	1,320,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,795,800.00	2,127,400.00
2105	Нормативт зардал	64,271,400.00	59,204,820.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	886,800.00	328,920.00
210502	Хоол, хүнс	63,384,600.00	58,875,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,637,105.00	14,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	378,000.00	-
210604	Урсгал засвар	18,259,105.00	14,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,492,000.00	23,440,500.00
210702	Дотоод албан томилолт	12,492,000.00	23,440,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,060,928.00	15,917,706.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	9,455,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,328,000.00	1,612,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,720,600.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,809,374.00	1,835,374.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	781,000.00	836,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	672,000.00	592,000.00
210807	Газрын төлбөр	1,749,954.00	1,586,532.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,833,400.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	860,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,973,400.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,270,892.00	31,336,154.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,534,000.00	8,483,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,534,000.00	8,483,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	38,736,892.00	22,853,154.99
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,736,892.00	22,853,154.99
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,270,000.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	20,270,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,270,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	20,270,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,270,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(20,270,000.00)	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,307,549,861.72	779,882,903.13	4,218,324,123.40	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,307,549,861.72	779,882,903.13	4,218,324,123.40	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(121,971,382.57)	-
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,307,549,861.72	779,882,903.13	4,388,857,404.47	-
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,307,549,861.72	779,882,903.13	4,388,857,404.47	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,307,549,861.72	779,882,903.13	4,388,857,404.47	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(574,619,971.87)	-
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,307,549,861.72	779,882,903.13	3,814,237,432.60	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,251,149,700.00	2,228,296,545.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,251,149,700.00	2,228,296,545.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,246,252,900.00	2,223,498,545.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,814,593,700.00	1,807,926,483.00
210101	Үндсэн цалин	823,208,400.00	818,026,183.00
210102	Нэмэгдэл	950,003,300.00	950,003,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,382,000.00	39,897,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	67,379,400.00	52,820,396.00
210201	Тэтгэврийн даатгал	17,543,000.00	13,990,604.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,063,700.00	1,645,953.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,651,100.00	1,316,762.00
210204	Ажилгүйдлийн даатгал	412,700.00	277,278.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,708,900.00	35,589,799.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	277,085,300.00	276,037,443.91
210301	Гэрэл, цахилгаан	22,143,100.00	21,934,629.90
210302	Түлш, халаалт	242,455,300.00	241,653,365.01
210303	Цэвэр, бохир ус	12,486,900.00	12,449,449.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,755,900.00	6,546,696.10
210401	Бичиг хэрэг	1,539,100.00	1,587,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,615,700.00	1,511,536.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,532,300.00	1,320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,068,800.00	2,127,400.00
2105	Нормативт зардал	59,205,100.00	59,204,820.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	329,200.00	328,920.00
210502	Хоол, хүнс	58,875,900.00	58,875,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,733,500.00	6,462,706.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,612,800.00	1,612,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,835,700.00	1,835,374.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	836,000.00	836,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	592,000.00
210807	Газрын төлбөр	1,857,000.00	1,586,532.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,896,800.00	4,798,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,896,800.00	4,798,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,896,800.00	4,798,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,251,149,700.00	2,228,296,545.01
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,251,149,700.00	2,228,296,545.01
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,251,149,700.00	2,228,296,545.01

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,404,175.00	36,580,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,404,175.00	36,580,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,862,175.00	32,895,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,868,500.00	-
210402	Тээвэр шатахуун	8,868,500.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,489,675.00	-
210604	Урсгал засвар	4,489,675.00	-
2107	Томилолт, зочны зардал	11,304,000.00	23,440,500.00
210702	Дотоод албан томилолт	11,304,000.00	23,440,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	9,455,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	9,455,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,542,000.00	3,685,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,542,000.00	3,685,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,542,000.00	3,685,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29,404,175.00	36,580,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,404,175.00	36,580,500.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө	9,068,500.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,706,000.00	27,125,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,629,675.00	9,455,000.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Онцгой байдлын газар нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх замаар Монгол хүний аюулгүй амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлж улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Онцгой байдлын ерөнхий газарт тайлангаа нэгтгэдэг Шадар сайдын харьяа байгууллага юм.

Тус газар нь тайлант онд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах эрхзүйн орчныг сайжруулах
2. Штабын бэлтгэл, ажиллагааны удирдлагын чадавхыг бэхжүүлэх
3. Холбоо, зарлан мэдээлэл, цахим ашиглалтыг дээшлүүлэх

Төв аймгийн Онцгой байдлын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 45 арга хэмжээтэй баталснаас нийт 92,8%-тай дүгнэгдсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Онцгой байдлын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Онцгой байдлын ерөнхий газрын дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газраас дотоод аудитын үйл ажиллагааг удирдан явуулдаг бөгөөд газрын даргын 2023 оны А/14 дүгээр тушаалаар дотоод хяналт, шалгалтын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталж Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд төлөвлөгөөт хяналт шалгалтын чиглэлээр 10, төлөвлөгөөт бус дотоод хяналт шалгалтын чиглэлээр 2, гүйцэтгэлийн хяналтын чиглэлээр 2, нийт 14 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Төв аймгийн Онцгой байдлын газарт Онцгой байдлын ерөнхий газрын дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газраас 2020, 2021, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд иж бүрэн шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Онцгой байдлын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 15-ны А/293 дугаар тушаалаар батлагдсан шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Онцгой байдлын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 572,894.5 мянган төгрөгөөр буюу 8,8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	219.0	219.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	410,029.1	444,627.8	34,598.7
Үндсэн хөрөнгө	6,066,261.1	5,458,549.0	(607,712.1)
Нийт хөрөнгө	6,476,290.2	5,903,395.7	(572,894.5)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,476,290.2	5,903,395.7	(572,894.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,476,290.2	5,903,395.7	(572,894.5)

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 24,287.0 мянган төгрөг, аж ахуйн материал 1,300.0 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 4,960.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бичиг хэргийн материал 385.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн данс 303,995.5 мянган төгрөгөөр буурсан нь машин тоног төхөөрөмж 57,010.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тээврийн хэрэгсэл шилжүүлсэн 361,006.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,903,396.0 мянган төгрөг болж 572,895.0 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

Мөнгөн хөрөнгө, өглөгийн данс эхний, эцсийн үлдэгдэлгүй байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,444,295.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Онцгой байдлын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 96,343.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны урсгал зардлын төсвийг 2,540,638.9 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

Энэ нь тайлант онд төрийн албан хаагчийн цалин болон түлш халаалтын тариф нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант оны батлагдсан төсөв 2,540,638.9 мянган төгрөгөөс 4 удаа тодотгол хийж 2,251,149.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,251,149.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 22,853.1 төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,228,296.5 мянган төгрөг буюу 99,0 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой зардлуудыг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70708/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,246,252.9	2,223,498.5	22,754.4	99.0%
2	70708/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	4,896.8	4,798.0	98.8	98.0%
	ДҮН	2,251,149.7	2,228,296.5	22,853.2	99.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 27,125.5 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын Тамгын газраас 9,455.0 мянган төгрөг нийт 36,580.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Онцгой байдлын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дотоод албан томилолтод 23,440.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардалд 9,455.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 3,685.0 мянган төгрөг нийт 36,580.5 мянган төгрөг зарцуулж дансны үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	/мянган төгрөгөөр/		
				Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70708	2023.01.01-2023.12.31	Гамшгаас урьдчилан сэргийлэх	Хөтөлбөр 92.8 %	2,251,149.7	2,228,296.5

Төв аймгийн Онцгой байдлын газар нь төсвийн хэмнэлтийн горимд шилжин ажилласнаар цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд нийт 22,853.1 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, дутуу зарцуулсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлсөн байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төв аймгийн Онцгой байдлын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 223,038.3 мянган төгрөгийн цахилгаан дулаан, цэвэр бохир усны үйлчилгээг гэрээ шууд байгуулах аргаар, 12,777.9 мянган төгрөгийн барааг шууд худалдан авалтаар авахаар, 25,842.1 мянган төгрөгийн хоол хүнсний материалыг харьцуулалтын аргаар, нийт 261,658.3 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 341,788.9 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн өссөн нь төсөв тодотгон нэмэгдсэнтэй холбоотой байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Онцгой байдлын газрын 2023 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Онцгой байдлын газрын батлагдсан 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 2,335,499.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 35,032.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 26,274.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цахилгааны зардлыг хэмнэх, орон нутгийн алба хаагчдын хичээл сургалт, хурлыг цахимаар хийж, тээвэр шатахуун, томилолтын зардлыг хэмнэх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж 22,853.1 мянган төгрөгийн зардлыг хэмнэж, зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Онцгой байдлын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22 орлогын, 12 зарлагын мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 21 шийдвэрийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Онцгой байдлын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж хэрэгжээгүй байсан тул аудитын тайланд тусгасан болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 33/137 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	898.0	1	898.0	100%
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>898.0</b>	<b>1</b>	<b>898.0</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Онцгой байдлын газарт дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

### 5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 97,440.7 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 97,440.7 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

1. Үндсэн хөрөнгөнд 1,725.5 мянган төгрөгийн элэгдэл бодогдоогүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Төрийн сангаас бэлэн мөнгөний зарлагыг гаргахдаа арилжааны банкны дансаар дамжуулалгүй шууд жижиг мөнгөн санд орлого хийж бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Буцсан гүйлгээг тооцоо үүсгэлгүй орлого, зардал бууруулах бичилт хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4. Цалингийн урьдчилгааг шууд зардалд хааж бичсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

5. Үр дүнгийн тайлан хоол хүнс, урсгал засварын зардлын дүн Э-тайлангаас зөрүүтэй тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

6. Төсвийн гүйцэтгэлийн тайланд тээврийн хэрэгслийн оношилгоо, мэдээлэл технологийн зардлын төлөвлөгөө зөрүүтэй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар үндсэн хөрөнгийн данстай холбоотой нэг зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 зөвлөмж өглөө.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

#### **Илрүүлэлт:**

Байгууллагын дансанд бүртгэлтэй Фотон маркийн тракторыг тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын бүртгэлийн дугааргүй ашиглаж байна.

Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ын 3.2-д “Шинээр бүртгэсэн авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгоно” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Тээврийн хэрэгслийг шинээр бүртгүүлж, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын бүртгэлийн дугаарыг авч ашиглах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	6	97,440.7			6	97,440.7	6	97,440.7				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>97,440.7</b>			<b>6</b>	<b>97,440.7</b>	<b>6</b>	<b>97,440.7</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тээврийн хэрэгслийг гэрчилгээ, улсын дугааргүй ашиглаж байна.	1	0.0					1	0.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0.0</b>					<b>1</b>	<b>0.0</b>				